

**Монгол Улсад “Нэг эрүүл мэнд”-ийн зарчмыг хэрэгжүүлэх
арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө**

уулзалт хэлэлцүүлэг

2024.09.11-13

Монгол Улс, Улаанбаатар хот, Блю Скай зочид буудал



Индекс

Хураангуй	Хуудас 3
Товчилсон үгс	Хуудас 4
1. Суурь мэдээлэл	Хуудас 5
2. Зорилт	Хуудас 6
3. Оролцогчид	Хуудас 6
4. Уулзалт хэлэлцүүлгийн арга зүйн тойм	Хуудас 7
5. Хуралдааны үр дүнгүүдийн хураангуй	Хуудас 8
6. Үнэлэх судалгаа	Хуудас 15
7. Дүгнэлт	Хуудас 15
Хавсралт	
(i) Арга хэмжээний веб сайт	Хуудас 16
(ii) Бүлгийн ажлын үр дүн	Хуудас 16
(iii) Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн постууд	Хуудас 16

Хураангуй

2024 оны 9 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд 'Монгол Улсад Нэг эрүүл мэндийн зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө' сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тус арга хэмжээнд эрүүл мэнд, малын эрүүл мэнд, байгаль орчны салбар тус бүрээс ойролцоо тоотойгоор 78 төлөөлөгч оролцсон.

Оролцогчид Нэг эрүүл мэнд болон Үйл ажиллагааны зургаан чиглэл, Өөрчлөлтийн гурван замыг багтаасан Дөрвөн талт Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар сайтар ойлголт авсан. Уулзалт хэлэлцүүлэгт оролцооны аргыг өргөн ашигласан бөгөөд олон салбарыг хамарсан хэлэлцүүлэг нь оролцогчдын Нэг эрүүл мэнд болон харилцан бие биенийхээ ажил мэргэжлийн талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлсэн. Тэд Монгол Улсын Нэг эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны сул тал, бэрхшээлийг тодорхойлж, улмаар тэдгээрийг шийдвэрлэх зорилт, үйл ажиллагааг боловсруулсан. Уулзалт хэлэлцүүлгийн үр дүнд Үйл ажиллагааны чиглэл дэх гол зорилтуудыг эрэмбэлж, өөрчлөлт хийх замаар эдгээр зорилтод хүрэх үйл ажиллагааг эхний байдлаар боловсруулав.

Байгаль орчны салбарыг Нэг эрүүл мэндэд нэгтгэх нь (Дөрвөн талт Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөний Үйл ажиллагааны чиглэл 6) Монгол Улсын хувьд хамгийн чухал гэж тодорхойлсон. Тэргүүлэх зорилтууд нь Нэг эрүүл мэндийг зохицуулах чадавхтай механизм бүхий Нэг эрүүл мэндийн хороог (засаглалын бүтэц) байгуулахад гол анхаарал хандуулсан.

Оролцогч 3 яам буюу Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) тус уулзалт хэлэлцүүлэгт ач холбогдол өгч дэмжиж байгаагаа илэрхийлэн, Монгол Улсад Нэг эрүүл мэнд зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр ахиц гаргах амлалт өгсөн. Энэ зорилгоор буюу тус улсад Нэг эрүүл мэндийн үйл ажиллагааг урагшлуулах 3 багц зөвлөмж боловсруулсан. Үүнд:

- Монгол Улсад өгөх зөвлөмж
- Түншүүдэд өгөх зөвлөмж
- Дөрвөн талт байгууллагуудад өгөх зөвлөмж

Дээрх зөвлөмжүүдийн зорилго нь уулзалт хэлэлцүүлгийн үеэр тэргүүн зэрэгт эрэмбэлэгдсэн Нэг эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талуудын тогтвортой хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөр болон илтгэлийг [эндээс](#) авна уу (монгол, англи хэл дээр).

Товчилсон үгс

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ББТ	Бичил биетний тэсвэржилт
ХХААБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
МЭЭГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ОУЭМД	Олон улсын эрүүл мэндийн дүрэм
ХХҮ	Хөндлөнгийн хамтарсан үнэлгээ
СДЗМ	Салбар дундын зохицуулалтын механизм
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НЭМ СХҮХ	Нэг эрүүл мэндийн Салбар хоорондын Үндэсний хэлэлцүүлэг
НЭМ	Нэг эрүүл мэнд
НЭМ ХҮАТ	Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө
НЭМ ӨТШБ	Нэг эрүүл мэндийн Өндөр түвшний шинжээчдийн бүлэг
МЭАГ	Мал эмнэлгийн албаны гүйцэтгэл
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮББОХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр
АНУОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
ДБ	Дэлхийн Банк
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага

Суурь мэдээлэл

Нэг эрүүл мэнд (НЭМ) нь хүн, мал амьтан, ургамал болон хүрээлэн буй орчны газар нутгийн давхцалд эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн нэгдсэн аргачлал юм. Үүний зорилго нь нийтийн эрүүл мэнд, малын эрүүл мэнд, хүнс, тэжээллэгийн баталгаат байдал, экосистемийн тогтвортой менежмент, аюулгүй, шударга худалдааг дэмжихэд оршино.

Өнгөрсөн зуунаас бий болсон эдийн засаг, технологи, нийгмийн дэвшил нь хүн төрөлхтөнийг сайн сайхан байлгах дэлхийн хүчин чадалд ихээхэн дарамт учруулж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт; байгаль, биологийн олон янз байдал алдагдах; бохирдол, хог хаягдлын асуудлыг багтаасан Эх дэлхийн гурвалсан хямрал (Triple Planetary Crisis)-тай хавсарч, эрүүл мэндэд шинээр учирч буй аюул занал, тэр дундаа цартахал дэгдээх боломжтой халдварт өвчнүүдийг эрчимжүүлэв. Тухайлбал, шинэ болон сэргэж буй халдварт өвчнүүдийн 75% нь амьтнаас гаралтай бөгөөд Ази, Номхон далайн бүс нутаг анхаарал татдаг хэд хэдэн зоонз өвчин (мал амьтан болон хүний хооронд дамждаг өвчин)-ий эх үүсвэр болдог. НЭМ ба Эх дэлхийн гурвалсан хямралын уялдаа холбоонд хүний эрүүл мэнд, малын эрүүл мэнд, экосистемийн эрүүл мэнд, хүнсний баталгаат байдал нь салшгүй холбоотой гэсэн чухал ойлголт оршдог. Хувь хүн, олон нийт, мал амьтны эрүүл мэнд нь тэдний амьдарч буй экосистемийн эрүүл мэнд, аюулгүй, тэжээллэг хоол хүнс, усны хүртээмжтэй нягт холбоотой байдаг. Эдгээр элементүүдийн аль нэг нь тасалдах нь бүхэл бүтэн системийг доргиох дам нөлөө үзүүлж болно.

Сүүлийн үед НЭМ-ийн зарчим нь дэлхий, бүс нутаг, үндэсний хэмжээнд улам бүр хүлээн зөвшөөрөгдөх болов. Эрүүл мэндэд учирч буй аюул заналын нарийн төвөгтэй байдлыг харгалзан эрсдэлийг бууруулахын тулд олон салбар, мэргэжилтнүүд хамтран ажиллах шаардлага тулгарч байна. Экосистемийн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавих, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, хүн, мал амьтны популяцийн дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх нэгдсэн аргачлалууд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхний хүнсний баталгаат байдлыг хангахад тусалж чадна. Энэ нь Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030-ыг биелүүлэхэд нэн чухал юм.

Хүн-мал амьтан-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцал дах олон аюулыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-аас бүрдсэн Дөрвөн талт байгууллагууд Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (НЭМ ХҮАТ) болон түүнийг Хэрэгжүүлэх гарын авлага (The Implementation Guide of ОН JPA)-ыг боловсруулаад байна. Ази-Номхон далайн бүс нутагт хэрэгжиж буй арга хэмжээнүүдийг оролцуулан өнөөг хүртэл хуримтлагдсан түршлагад тулгуурлан Дөрвөн талт НЭМ ХҮАТ болон түүнийг Хэрэгжүүлэх гарын авлага нь НЭМ-ийн үндэсний бүтэц зохион байгуулалтаа бэхжүүлэхээр зорьж буй улс орнуудыг чиглүүлдэг.

2024 оны 9 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Блю Скай зочид буудалд зохион байгуулагдсан **‘Монгол Улсад Нэг эрүүл мэндийн зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө’** сэдэвт уулзалт хэлэлцүүлгээр зоонз болон бусад шинээр гарч буй халдварт өвчин, бичил биетний тэсвэржилт (ББТ), хүнсний аюулгүй байдалд анхаарал хандуулснаас гадна улсын хэмжээнд НЭМ-ийн чиглэлээр салбарууд хамтран ажилласны үр дүнд бий болсон ололт амжилт,

дутагдал, сургамжийн талаар эргэцүүлэх боломж олгосон юм. Тус уулзалт хэлэлцүүлэг нь Дөрвөн талт НЭМ ХҮАТ болон түүнийг Хэрэгжүүлэх гарын авлагыг ашиглан өөрийн орны нөхцөл байдалд нийцсэн НЭМ ХҮАТ боловсруулахад нь Монгол Улсад дэмжлэг үзүүлнэ.



Зорилт

1. Хүн-мал амьтан-ургамал, хүрээлэн буй орчны газар нутгийн давхцал дах НЭМ-ийн асуудал болон Дөрвөн талт НЭМ ХҮАТ, түүнийг Хэрэгжүүлэх гарын авлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх;
2. НЭМ-ийн зохицуулалтын ахиц дэвшил, тулгарч буй сорилтуудыг эргэж нягтлан өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийх замаар цаашдын үялдаа холбоо бүхий арга замыг төлөвлөх;
3. Өөрийн орны нөхцөл байдалд нийцсэн НЭМ ХҮАТ/стратегийн хүрээг Дөрвөн талт НЭМ ХҮАТ болон түүнийг Хэрэгжүүлэх гарын авлагын дагуу боловсруулахад нь Монгол Улсад дэмжлэг үзүүлэх.

Оролцогчид

Эрүүл мэнд, малын эрүүл мэнд, зэрлэг ан амьтад, байгаль орчин, хүнсний аюулгүй байдлын салбар, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд, хандивлагчид, түншүүдийн төлөөлөл болсон 78 хүн оролцсон. Салбар бүрийн төлөөлөгчид Дөрвөн талт НЭМ ХҮАТ-ний Үйл ажиллагааны 6 чиглэлийг бүрэн төлөөлж чадсан. Дөрвөн талт байгууллага, бүсийн болон Монгол Улс дах төлөөлөгчийн газрын ажилтнуудыг чиглүүлэгч болон мэргэжлийн мэдээллээр хангах багт оруулсан.

Нүүр хагарах дасгалыг ашиглан оролцогчдын хүйс, салбарыг тодорхойлов. Эмэгтэй оролцогчид тооны хувьд давуу байсан. Хамгийн олон оролцогч эрүүл мэндийн салбараас (хүнсний аюулгүй байдлын салбарыг оролцуулан) байсан бол малын эрүүл мэнд, байгаль орчны салбаруудаас оролцогчдын тоо тэнцүү байв.



Уулзалт хэлэлцүүлгийн арга зүйн тойм

Уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөр болон илтгэлүүдийг арга хэмжээний цахим хуудсанд байршуулсан (Хавсралт (i)-т үзүүлсэн холбоосоор ор).

Уулзалт хэлэлцүүлгийн агуулга нь нэгдсэн илтгэл, бүлгийн ажил, асуулт хариултын хэсгүүдээс бүрдсэн. Илтгэлүүдийг монгол, англи хэл дээр орчуулсан. Оролцогчдын дунд өрнөх хэлэлцүүлгийг дэмжих үүднээс арга хэмжээний туршид монгол-англи хэлээр синхрон орчуулга хийсэн.

Хуралдаан 1: Нээлтийн арга хэмжээ ба Нэг эрүүл мэндийн танилцуулга

ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Очирбат, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Төмөрбаягийн Жамбалцэрэн, БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Эрхэмбаярын Баттулга нар арга хэмжээг нээж үг хэлэв. Үүний дараа Дөрвөн талт байгууллагуудын төлөөлөгчид үг хэлсэн. Үүнд: Др. Хирофуми Кугита (ДМАЭМБ-ын Ази, Номхон далайн бүсийн төлөөлөгч), Др. Сокорро Эскаланте (ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч), Др. Винод Ахужа (НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгч), хатагтай Макико Яширо (НҮББОХ-ийн Ази, Номхон далайн бүс).

Уулзалт хэлэлцүүлгийн зорилтын тоймыг Mentimeter®-ээр нүүр хагарах асуулт хариулт явуулах, бүлгээрээ зураг авахуулахаас өмнө оролцогчдод танилцуулсан.

Хуралдаан 2: Ерөнхий мэдээлэл: Нэг эрүүл мэнд ба Нэг эрүүл мэндийн чиглэлээр дэлхий, бүс нутаг, улс орнуудын түвшинд хэрэгжүүлж буй санаачилгууд

НЭМ-ийн ухагдахуун, Дөрвөн талт үйл ажиллагаа, Дөрвөн талт НЭМ ХҮАТ, Эх дэлхийн гурвалсан хямралын тухай хэд хэдэн илтгэлээр танилцуулсан. Дараа нь Монгол Улсын гурван салбарын (эрүүл мэнд, малын эрүүл мэнд, байгаль орчин) төлөөлөгчид үндэсний хэмжээнд НЭМ-ийн чиглэлээр гарч буй ахиц дэвшил, хэрэгцээ шаардлагын талаар товч танилцуулсан. Мөн тус улсад НЭМ-ийн чиглэлээр хэрэгжиж буй гол төслүүдийн талаар цухас мэдээлэл хүргэв.

Хуралдаан 3: Монгол Улсад хэрэгжүүлж буй Нэг эрүүл мэндийн санаачилгууд – нөхцөл байдлын дүн шинжилгээ

Бүх оролцогчдод НЭМ-ийн зарчмыг ашиглан шийдвэрлэх гол асуудлуудын талаар мэдлэг олгох зорилгоор том цагаан цаас ашиглан World Café маягийн бүлгийн ажил хийлгэсэн. Оролцогчид НЭМ ХҮАТ-ний Үйл ажиллагааны 6 чиглэлийн дагуу Монгол Улсад явагдаж буй үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлсон.

Хуралдаан 4: Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө

НЭМ ХҮАТ-ний Өөрчлөлтийн замыг тоймлон, Mentimeter® ашиглан нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулав. Сонирхлынх нь дагуу бүлэг тус бүрт гурван салбарын төлөөлөл оролцуулан НЭМ ХҮАТ-ний Үйл ажиллагааны чиглэл тус бүрээр Монгол Улсад хэрэгжүүлж буй арга хэмжээний сул талуудыг хэлэлцүүлж, үр дүнг Excel® файлын загварт оруулсан. Үүнд тулгуурлан оролцогчид Өөрчлөлтийн гурван замтай холбоотойгоор тус улсад тулгарч буй тодорхой хэдэн сорилтуудыг авч үзсэн.

Хуралдаан 5: Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөг Нэг эрүүл мэндийн тогтолцоонд тусгах

Өмнөх хуралдааны үр дүнд үндэслэн НЭМ ХҮАТ-ний Үйл ажиллагааны чиглэлүүдийн дагуу 6 бүлэгт хуваагдан (оролцогчид сонирхол, мэргэшлийнхээ дагуу бүлгүүдийг сонгосон) Монгол Улсад НЭМ зарчмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. Өөрчлөлтийн 3 замын дэд бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн зорилтыг тодорхойлсон. Тэргүүлэх байгууллага, агентлаг болон хамтран ажиллах салбарууд, үйл ажиллагааны үр дүнд бий болох бүтээгдэхүүн (орцын хамт PowerPoint® слайдын загварт оруулав) болон оролцогч талуудын үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг нарийвчлан тодорхойлсон. Оролцогчдод зорилт, үйл ажиллагааны бичвэрийг хэвлэж тараан, эрэмбэлэх санал хураалт явуулсан.

Хэд хэдэн түншүүдийг хамруулсан мэргэжилтнүүдийн хэсэг Монгол Улсад тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх НЭМ-ийн санхүүжилтийн боломж ба хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэв.

Хуралдаан 6: Зөвлөмж, дараагийн алхмууд, хаалт

Монгол Улсад хэрэгжүүлж болох дараагийн алхамд зориулж НЭМ-ийн үндэсний салбар дундын зохицуулалтын механизмын зарим жишээ болон НЭМ ХҮАТ-ний хүрээнд хэрэгжүүлэх “Үндэсний НЭМ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар”-ыг танилцуулав.

Тус улсад НЭМ-ийн зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын саналыг авсан. Төлөвлөлтийн багийн боловсруулсан Зөвлөмжийн төслийг оролцогчдод танилцуулсан. Салбарын төлөөллөөс бүрдсэн хэсэг уулзалт хэлэлцүүлгийн дараа үргэлжлүүлэн ажиллах амлалт өгсөн. Арга хэмжээг хааж ДЭМБ (Др. Сокорро Эскаланте) болон ДМАЭМБ (Др. Хирофуми Кугита) үг хэлэв.

Оролцогчдын оролцоог үнэлэх, цаашдын арга хэмжээг сайжруулах зорилгоор богино хэмжээний цахим үнэлгээний судалгаа авсан. Уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөр, илтгэлүүдийг оролцогчдод цахимаар илгээсэн.

Хуралдааны үр дүнгийн хураангуй

Хуралдаан тус бүрийн үр дүнг Хавсралт (ii)-т үзүүлэв.

Хуралдаан 1: Нээлтийн арга хэмжээ ба Нэг эрүүл мэндийн танилцуулга

ЭМЯ, ХХААХҮЯ, БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол, мал амьтны хил дамжин халдварладаг өвчнүүд, зооноз өвчин зэрэг Монгол Улсад тулгарч буй гол асуудлуудыг онцлон тэмдэглэв. Эдгээр асуудлыг бусад салбартай хамтран шийдвэрлэх хүсэлтэй байгаагаа тэд бүгд илэрхийлсэн. Дөрвөн талт түншүүд (ХХААБ, НҮББОХ, ДЭМБ, ДМАЭМБ)-ийн төлөөлөгчид НЭМ зарчмыг ашиглан нийтлэг тохиолддог аюул заналын эсрэг арга хэмжээгээ бэхжүүлж чадсан ажлынхаа жишээг танилцуулав.

Хуралдаан 3: Монгол Улсад хэрэгжүүлж буй Нэг эрүүл мэндийн санаачилгууд – нөхцөл байдлын дүн шинжилгээ

Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлыг НЭМ ХҮАТ-ний Үйл ажиллагааны 6 чиглэлтэй уялдуулж бүлгээрээ хэлэлцэв



Үйл ажиллагааны чиглэлтэй холбоотойгоор Монгол Улсад хэрэгжиж буй НЭМ-ийн гол үйл ажиллагаа буюу арга хэмжээнүүд:

1. **НЭМ-ийн чадавх:** Салбар дундын зарим арга хэмжээг (жишээ нь, Олон улсын хүнсний аюулгүй байдлын өдөр, ББТ-ийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах дэлхийн 7 хоногийг тэмдэглэх) хэд хэдэн төсөлтэй хамтарч хэрэгжүүлдэг. НЭМ-ийн сургалт, олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах кампанит ажил системтэй явагддаг. Шадар сайдын А/28 тоот тушаалын дагуу халдварт өвчний тохиолдлуудад НЭМ зарчмыг мөрддөг. Хамтарсан хороо байгуулж (А499), НЭМ-ийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон.
2. **Шинэ болон сэргэж буй зооноз эпидеми ба цартахал:** Гурван салбар энэ чиглэлээр судалгаа шинжилгээ, чадавх бэхжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Зооноз өвчнийг оношлох лабораторийн чадавх сайжирч байна. Хэд хэдэн үнэлгээ, үйл ажиллагаа зохион байгуулсан (жишээ нь, Хөндлөнгийн хамтарсан үнэлгээ, Мал эмнэлгийн албаны гүйцэтгэлийн үнэлгээ, Нэг эрүүл мэндийн Салбар хоорондын Үндэсний хэлэлцүүлэг), энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хууль журам гарсан.
3. **Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд болон дамжуулагчдаар дамждаг өвчнүүд:** Хүн, мал эмнэлгийн салбарын Хамтарсан зохицуулах хороог байгуулсан. Зооноз өвчний тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг, дэгдэлтийн зарим хариу арга хэмжээг хамтарч хэрэгжүүлдэг. Жишээ нь, боом, бруцеллёз, төрөл бүрийн хүнсээр дамждаг эмгэгтөрүүлэгчдийг багтаасан хэд хэдэн зооноз өвчнийг хамруулдаг.
4. **Хүнсний аюулгүй байдал:** Кодекс Алиментариус хүнсний аюулгүй байдлын стандартыг монгол хэлнээ хөрвүүлэн үндэсний стандарт болгон баталсан. Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний зохицуулалтын механизм (Шадар сайдын А/28 тоот тушаал), холбогдох хэд хэдэн хууль журмыг мөрддөг. Энэ чиглэлээр лабораторийн чадавх сайжирч байна.
5. **ББТ:** Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг үндэсний хэмжээний томоохон засаглалтай (2022-2025 он). Салбаруудад лабораторийн сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд ББТ-тэй холбоотой хэд хэдэн үнэлгээ хийсэн. ББТ-ийн үндэсний мэдээлэл

Үйл ажиллагааны чиглэлийн Өөрчлөлтийн замтай холбоотой НЭМ-ийн сул тал, сорилтууд Монгол улсад дараах байдалтай байна:

1. **НЭМ-ийн чадавх:** Үйл ажиллагааны бүх талбарыг “шаардлагатай” гэж тодорхойлсон (ө.х., сул тал). Хэд хэдэн чиглэлээр хууль тогтоомж боловсруулсан гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, салбарын интеграцлалд олон бэрхшээл тулгардаг, "салбарын манлайлал, зохицуулалт дутмаг" гэж нэлээд дурдагдсан. НЭМ-ийн чадавх бэхжүүлэхтэй холбоотойгоор НЭМ-ийн дараа үеийн мэргэжилтнүүдийг дэмжих шаардлагатай байгаа бөгөөд ажлын байр тогтворгүй, байнга солигддог, нэгж хооронд мэдээлэл солилцох тал дээр дутагдалтай байна.
2. **Шинэ болон сэргэж буй зооноз эпидеми ба цартахал:** Салбар бүрт зооноз өвчнийг зохицуулсан хууль байдаг ч нэгдсэн зохицуулалт байхгүй. Бодит амьдрал дээр салбар бүр тус тусдаа сургалт, ажил (хөдөө орон нутагт хамтарсан баг томилогдож ажиллах нь хязгаарлагдмал) болон олон нийтийн мэдээлэл харилцааг зохион байгуулдаг. Цаашлаад өвчний мэдээлэл солилцох нээлттэй нэгдсэн систем байхгүй. Сорилтууд нь хуулийн зохицуулалтаас эхлээд хэрэгжилтийн хамтарсан зохицуулалт, нэгдсэн мэдээлэл солилцох арга хэмжээ хүртэл Өөрчлөлтийн гурван замыг гурвууланг нь хамарсан.
3. **Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд болон дамжуулагчдаар дамждаг өвчнүүд:** Энэ хэсэгт хуулиуд хоорондын уялдаа холбоо дутмаг байгаад гол анхаарал хандуулсан. Мөн шийдвэр гаргагчдын НЭМ-ийн талаарх ойлголт дутмаг, байгаль орчны салбар одоогоор НЭМ-ийн бүрэлдэхүүнд хараахан ороогүй байна. Төсөв дутмаг байгаа нь засаглал, сурталчилгааны ажилд томоохон сорилт болж байна. Хэрэгжилтийг хангуулах НЭМ-ийн хариуцлагатай баг болон НЭМ-ийн хариу арга хэмжээний зааварчилгаа байхгүй. Мэдээлэл солилцох уулзалтыг тодорхой давтамжтай зохион байгуулдаггүй, өвчнийг мэдээлэх нэгдсэн платформ байхгүй.
4. **Хүнсний аюулгүй байдал:** Хүнсээр дамждаг өвчний тандалтын чадавх бэхжүүлэх, хууль эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн сахин мөрдөлтийг сайжруулах шаардлагатай байна. Сорилтуудад үйл ажиллагааны хэд хэдэн чиглэлээр хууль эрх зүйн орчныг бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх асуудал багтана. БОУАӨЯ-нд хүнсний аюулгүй байдлыг хариуцдаг бүтэц байхгүй бөгөөд мэргэжлийн үр чадвар, мэргэжилтэн бэлтгэхэд бэрхшээл тулгардаг. Тогтвортой мэдээлэл солилцох буюу салбар хооронд мэдээлэл солилцох нэгдсэн платформ байхгүй.
5. **ББТ:** Холбогдох бодлого, лабораторийн оношилгоо, хүний нөөцийн чадавх бэхжүүлэх сургалт, олон нийтийн мэдлэг хандлагыг сайжруулах тогтолцоо сул байгаа зэрэг олон дутагдлыг тодорхойлсон. Салбар дундын хууль эрх зүйн орчин дутмаг байгаа нь томоохон сорилт болж байна. Хэрэгжилтийн хувьд санхүүжилт хангалтгүй, байгууллагуудын оролцоо сул байна. Мэдээллийн нэгдсэн систем байхгүй.
6. **Байгаль орчны салбарыг нэгтгэх:** Одоогоор НЭМ-ийн үндэсний зохицуулалт бүхий бүтэц, стратеги төлөвлөгөө байхгүй байна. Байгаль орчны салбар нь НЭМ-ийг стратеги, төлөвлөгөө гэх мэт баримт бичигтээ тусгаагүй бөгөөд нөгөө талаар, байгаль орчны салбар нь үндэсний НЭМ-ийн үйл ажиллагаанд хамрагдаагүй. Хууль тогтоомж боловсруулахдаа бусад салбарын оролцоог хангадаггүй, орон нутгийн иргэдийн үүргийг сурталчлах ажил, амьд мал амьтны захын зохицуулалт дутмаг байна. НЭМ-ийн сургалт, орчны эрүүл мэндийн үнэлгээ хийх шаардлагатай. Талуудын хооронд сайтар төлөвлөсөн мессеж түгээх, мэдээлэл хуваалцахад бэрхшээлтэй.

Бүх салбарт тодорхойлогдсон гол бэрхшээлүүд:

- Хамтарсан үйл ажиллагаа, мэдээлэл солилцох ажиллагааг дэмжих салбар дундын зохицуулалтын механизм дутмаг.
- Гурван салбарыг холбосон үндэсний засаглалын албан ёсны бүтэц байхгүй. Салбарууд нэгдсэн стратеги буюу хүрээ байхгүйн улмаас уялдаа холбоогүй тус тусдаа олон санаачилга хэрэгжүүлдэг (жишээ нь, тандалт, эрсдэлийн үнэлгээ).
- Салбаруудын одоо мөрдөж буй хууль тогтоомж, хууль эрх зүйн орчин сайтар уялдаагүй.
- Санхүү, хүний нөөц, хамтарсан үйл ажиллагаа, зохицуулалт хийх чадавх хангалтгүй. Энэ нь санаачилгуудыг тогтвортой хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулдаг.

Хуралдаан 5: Нэг эрүүл мэндийн Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөг Нэг эрүүл мэндийн тогтолцоонд тусгах

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын тодорхойлсон зорилтууд (Зорилт тус бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт (ii)-д оруулсан.

1. **НЭМ-ийн чадавх**
 - a. Бодлого, хууль тогтоомж: НЭМ-ийн механизмыг бэхжүүлэх
 - b. Байгууллагын хөгжил: НЭМ-ийн чиглэлээр ажиллах хүчнийг чадавхжуулах
 - c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг: НЭМ-ийн мэдлэг, хандлагыг сайжруулах
2. **Шинэ болон сэргэж буй зооноз эпидеми ба цартахал**
 - a. Бодлого, хууль тогтоомж: НЭМ зарчмын дагуу хууль эрх зүйн чадамж эзэмших
 - b. Байгууллагын хөгжил: Шинэ болон сэргэж буй зооноз өвчний нутагшмал болон эпидемик дэгдэлтийн эрсдэлийг бууруулах
 - c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг: Нэгдсэн системээр эрт сэрэмжлүүлэх замаар эрсдэлийг бууруулах
3. **Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд болон дамжуулагчдаар дамждаг өвчнүүд**
 - a. Бодлого, хууль тогтоомж: Зооноз өвчинтэй тэмцэх, сэргийлэх, тандалтын арга хэмжээний салбар дундын эрх зүйн орчныг НЭМ-ийн зарчимд нийцүүлж бэхжүүлэх
 - b. Байгууллагын хөгжил: Зооноз өвчний чиглэлээр оролцогч талуудын хүний нөөцийн чадавх, бэлэн байдлыг сайжруулж, салбар дундын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах
 - c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг:
 - i. Салбар дундын мэдээллийг сайжруулж, зооноз өвчний нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх
 - ii. Зооноз өвчний салбар дундын мэдээлэл солилцоог сайжруулж, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх.
4. **Хүнсний аюулгүй байдал**
 - a. Бодлого, хууль тогтоомж: Хууль, эрх зүйн шинэчлэл
 - b. Байгууллагын хөгжил: Хүнсний аюулгүй байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх
 - c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг: Хүнсээр дамждаг өвчний тандалт, мэдээлэл солилцоог сайжруулах


5. ББТ

- a. Бодлого, хууль тогтоомж: НЭМ-ийн оролцогч талуудад зориулж ББТ-ийн хууль эрх зүйн орчинтой болох
- b. Байгууллагын хөгжил: ББТ-ийн зохицуулалт бүхий үйл ажиллагааг бэхжүүлэх
- c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг: ББТ-ийн нэгдсэн тандалтын мэдээлэл солилцох мэдээллийн сан байгуулах

6. Байгаль орчны салбарыг нэгтгэх

- a. Бодлого, хууль тогтоомж: ЭМЯ, ХХААХҮЯ, БОУАӨЯ хооронд салбар дундын хамтын ажиллагааг зохицуулах Нэг эрүүл мэндийн хороо байгуулах
- b. Байгууллагын хөгжил: Яам, агентлагийн түвшинд, ялангуяа байгаль орчны салбарт НЭМ-ийн чиглэлийн байгууллагын чадавх, нөөцийг нэмэгдүүлэх
- c. Өгөгдөл/нотолгоо/мэдлэг: Салбар дундын мэдээллийн нэгдсэн платформыг сайжруулж, байгаль орчны салбараас НЭМ-тэй холбоотой шаардлагатай өгөгдөл, мэдээлээр хангах. Стратегийн хувьд нэгдсэн НЭМ-ийн өгөгдөл мэдээллийг олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах, сурталчилгааны ажилд ашиглах.

Үйл ажиллагааны чиглэлүүдээс ҮАЧ 6 (Байгаль орчны салбарыг Нэг эрүүл мэндэд нэгтгэх) 167 саналын 37-г авсан нь түүнийг тэргүүлэх гол чиглэл гэж үзэж байгааг илтгэж байна. Тэргүүлэх зорилтууд нь ихэвчлэн улсын хэмжээнд салбар хоорондын хамтын ажиллагааг хангахтай холбоотой байв. Хамгийн олон санал авсан 5:



Азийн Хөгжлийн Банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон Дэлхийн Банкны төлөөлөгч тус бүр өөрсдийн анхаарал хандуулж буй чиглэлээ тоймлон, НЭМ-ийн асуудлаар Монгол Улсын түншүүдтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн.

Хуралдаан 6: Зөвлөмж, дараагийн алхам, хаалт

НЭМ ХҮАТ-ний шаталсан аргачлал нь уулзалт хэлэлцүүлгийн үеэр хийсэн шиг нөхцөл байдлын дүн шинжилгээнээс эхэлдэг. Дараагийн алхам нь НЭМ-ийн засаглал, зохицуулалтыг бий болгох, бэхжүүлэх явдал тул НЭМ-ийн засаглалын ерөнхий бүтцийг багтаасан салбар дундын зохицуулалтын механизм болон бусад улс орнуудын жишээнүүдийн талаар ярилцав. Дөрвөн талт НЭМ ХҮАТ-г Хэрэгжүүлэх гарын авлагад үндэсний НЭМ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад ашиглаж болох загвар (уулзалт хэлэлцүүлгийн үеэр ашигласан Excel файльтай төстэй) болон ийм төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслах НЭМ-ийн бусад арга хэрэгслийн талаарх мэдээлэл багтсан. НЭМ-ийн арга хэмжээг хэрэгжүүлэх дараагийн алхмуудын талаарх нэгдсэн хэлэлцүүлгийн нэг асуудал нь салбаруудын хамтарсан үйл ажиллагааг баталгаажуулах явдал байв. Салбар тус бүрийг төлөөлсөн мэргэжилтнүүдийн бүлэг (Др. Б.Туяа (ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын Халдварт өвчний хэлтсийн дарга), Др. Бат-Амгалан (БОУАӨЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга), Др. Болдбаатар (Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга)) тус уулзалт хэлэлцүүлгийн дараа шууд хэрэгжүүлэх арга хэмжээг зарлав:

- НЭМ-ийн хороог ажиллуулах
- Салбар хоорондын зохицуулалтыг сайжруулахын тулд дижитал солилцох платформыг өргөжүүлэх
- Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө батлахын тулд техникийн бүлгүүд байгуулж, яамд хоорондын уялдааг хангах.

Зөвлөгөөний үеэр Монгол Улс, түншүүд болон Дөрвөн талт байгууллагуудад зориулсан зөвлөмж боловсруулсан. Эдгээр нь НЭМ ХҮАТ-ний хүрээг ашиглан НЭМ зарчмыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ. Зөвлөмжийг уулзалт хэлэлцүүлгийн дараа оролцогчидтой хамтран эцэслэн боловсруулсан ([МОНГОЛ](#), [АНГЛИ](#)).

Үнэлэх судалгаа

Цахим судалгаанд оролцогчид уулзалт хэлэлцүүлэгт өндөр оноо өгсөн (дундаж үнэлгээ 4.18/5) бөгөөд тэдний харьяа байгууллагын чиг үүрэгт хүчтэй нөлөө үзүүлнэ гэж үнэлжээ (дундаж 4.13/5). Оролцогчид олон салбарыг хамарсан форум зохион байгуулж хэлэлцүүлэг хийх боломж олгосонд талархаж, бусад салбартай хамтран ажиллах чин хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Дүгнэлт

НЭМ ХҮАТ сэдэвт үндэсний семинар амжилттай зохион байгуулагдаж өндөрлөв. Монголын түншүүд НЭМ-ийн бүтэц тогтолцоогоо урагшлуулах амлалт авав. Тодорхойлсон үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд илүү үр дүнтэй, санхүүжилттэй хэрэгжүүлэхэд гурван салбарыг адил тэгш оролцуулахын тулд НЭМ-ийн зохицуулалтын механизм ажиллах шаардлагатай байна.

Хавсралт (i): Арга хэмжээний вэб сайт

<https://rr-asia.woah.org/202409OHMongolia>



Хавсралт (ii): Бүлгийн ажлын үр дүн



Mongolia OH
JPA_session 3.pdf



Mongolia OH
JPA_session 4.pdf



Mongolia OH
JPA_session 5.pdf

Хавсралт (iii): Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн постууд

Х пост №1

<https://rr-asia.woah.org/2024OHM01>



Х пост №2

<https://rr-asia.woah.org/2024OHM02>





Food and Agriculture
Organization of the
United Nations



UN
environment
programme



World Health
Organization



World Organisation
for Animal Health
Founded as OIE

National Workshop on One Health Joint Plan of Action

11-13 September 2024

Session 3: One Health initiatives in Mongolia - situation analysis

Group work outputs



Action track 1: Enhancing One Health capacities to strengthen health systems

OH coordination	OH competencies and capacity	Policy, legislation	Operationalizing OH initiatives	Other
<ul style="list-style-type: none"> • No inter-sectoral coordination • Each Ministry has only one person responsible for OH • Celebrating international events (Food safety day, AMR awareness week etc) • NBW in 2022 • No data sharing mechanism between sectors • Risk communication Pilot projects in western 5 provinces • Experts exchange information via private channels • Environmental health surveillance 	<ul style="list-style-type: none"> • There is no integrated curriculum on OH • Conduct systematic training on OH • Improve public health capacity • Improve public awareness • Lack of practical training • Citizens lack understanding of public health • Conducted international assessment • Need to conduct train local experts on OH • Avian influenza assessment • OH related projects are implementing • Small-scale pilots have been conducted (Uvurkhangai province) • Protected area strengthening project (KFW) • Climate change adaptation project (KFW) • Glander and tuberculosis project SATREPS (JICA) • Mongolian Field Epidemiology Training Program (MFETP) 	<ul style="list-style-type: none"> • Need to conduct legal assessment on OH • No legal framework on implementation of OH • The approved legislation does not apply • Develop and implementation of long-term strategy • Human and animal drug laws are separated • Operates in accordance with the Deputy Prime Minister's Order No. A/28 in cases of infectious diseases • NAP of AMR • Health sector resilience plan 2024-2027 (A/180) 	<ul style="list-style-type: none"> • Has an overly ambitious plan • No financial agreements • There is no unified information system • Develop a manual on how to collaborate across all sectors • Improve risk assessment capacity • Implementation of measures appropriate to the characteristics of the region and geography • Conducting international workshops • Joint committee established/A499/ • OH country profile ready 	<ul style="list-style-type: none"> • Improving capacity of microbiology labs to detect hospital acquired infection • Zoonotic disease surveillance • Prioritize activities

Action Track 2: Reducing the risks from emerging and re-emerging zoonotic epidemics and pandemics

Overview

- Research activities for zoonotic diseases
- Animal Health and Environment monitoring for domestic and wildlife populations
- Strategic plans: Brucellosis and animal vaccination (12mi livestock animals); Updateing strategy to reduce vaccination and link with zoonotic scope at the human-animal interface

Key take aways

- Three sectors have ongoing activities in this area, including research and capacity building
- *Support for donor – risk of sustainability
- Laboratory capacity for zoonotic diseases are improving
- *Human health oriented
- Assessments: JEE, NBW, PVS (2019)
- Law and regulations (AH, PH law)

Challenges:

- Unified risk communication actions in continuity (All project based)
- Coordination between sectors

Human health	Environment	Animal
		Translating guidelines (WOAH) on Emerging and re-emerging animal disease into Mongolian Research study on Rabies and toxoplasma-Institute of veterinary medicine (Japan)
		Laboratory and field training (drug residue, HASSP, NCD, horse disease, serology and microbiology, parasitology, pathology, and quarantine –from JICA-MJ-VET
	Research on zoonotic disease of wildlife besides livestock	SATREPS international project on “Control for Tuberculosis and Glanders”

	FMD disease survey with environment sector (gazelle and other animals)	
SMART to MAHIS	SMART to MAHIS	

On other Action Tracks:

- Strategy for brucellosis is being updated to stop the difference between data of GAVS and NCZD.

Further actions:

- Improve the collaboration of GAVS and NCZD on data sharing
- Strengthen Risk communication for public on zoonotic diseases
- Improve hygiene regime or practice of herding livestock

Action track 3: Controlling and eliminating endemic zoonotic, neglected tropical and vector-borne diseases

1. Activities have been and are being done:

- Established a Joint Coordination Committee (human and animal health)
- Zoonosis surveillance
- Zoonosis border control (NCZD with Russia and China)
- Brucellosis surveillance in both human and animal
- Rabies, listeriosis and anthrax prevention on outbreak based only
- Brucellosis strategy in animal
- Joint emergency outbreak response in case of Covid-19, at beaver farm.
- Joint surveillance for tick-borne disease (NCZD and SCVL; IVM and MoECC)
- Joint simulation training regionally
- FETP training (exclusive the environment staff at the moment)
- Lab capacity to diagnose human zoonosis at local level
- Assessment of zoonosis labs of health sector for readiness
- Anthrax foci mapping in Khuvsgul
- Primary training for environment staffs
- Surveillance for food-borne caused by Salmonella, Campylobacter, and Cryptosporidium
- Disposal of animal carcasses in vet sector every year
- Policy and legal framework is in its initial phase

2. Issues that have been addressed during the group work:

- Action track is included in the objectives of the environmental sector
- Additional neglected diseases are Contagious ecthyma, equine virus abortion in veterinary sector
- Almost no joint medical and veterinary work and research in vector-borne diseases
- Lack of cooperation among one health relevant stakeholders
- We must have a realistic study on human and livestock diseased by zoonosis, allocate the budget for surveillance and detection
- Update the exchanged information between NCZD and GAVS
- Improve the study on invasive wildlife and plants that is done at Mongolian Academy of Science

Action Track 4: Strengthening the assessment, management and communication of food safety risks

Overview

- INFOSAN was established in 2004.
- Weak inspection system for food safety
- Food safety Codex standards translated and approved as National Standard
- National coordination mechanism – DPM order #28

Key take aways

- Three sectors have ongoing activities in this area, including research and capacity building

*Support for donor – risk of sustainability

- Laboratory capacity for food safety are improving - Under the National Standard and Measurement Agency

- Assessments: JEE (2023), NBW (2022), PVS (2019), FS survey (2023),

- Law and regulations (Food act-2012, PH law-2024, Code for Hygiene-2016, Law on Living genetically modified organism-2007, Codex standard-2003, Organic product law-2024, Act on Animal Health-2017, Food Supply and security program 2022-2027)

- Food Revolution National Program under President
- National Food Safety steering committee established in 2022

Challenges:

- Coordination between sectors

Human health	Animal	Environment
Food poison outbreak investigation	Veterinary certificate. Meat technical regulation (Government order 2022).	Protect forest from pesticide, chemical poisons Control of chemicals used in agriculture
Serial standard related LGMO food-	Controlling tests for anthrax and cholera in high-risk areas of 21 provinces and 9 districts according to NCZD order.	SANIPATH survey-2024 (water and food safety)
NCCD-food borne disease detection, investigation-MOH order 2018	Responsible nomads badge standards	Research published on – plant poisoning-2014 – heavy metal toxicity –2020
Brucellosis surveillance and detection	Animal health, food and environmental evaluations supported by mining sector	

<p>Training in food borne disease funded by JICA (2022-) ongoing</p> <p>Training organized by MOH - laboratory 2016, 2022 - customers – every year -chief – health organization</p> <p>COVID-19 risk management & research- national level, supported by FAO, effect on food supply chain during COVID-19</p> <p>Participated in the training on “Preparedness and Response for Mass Gatherings and Other Health Threats in Central Asia (PRECA)”, implemented by the International Science and Technology Center (ISTC) (EU CBRN CoE Project 87) (2022)</p>	<p>Research on Campylobacter, E.coli in food (meat) conducted by IVM since 2017</p> <p>Order on prohibit food from wild animal</p> <p>Enrolled PTAST – national food and veterinary labs</p>	
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--



Action track 5: Curbing the silent pandemic of antimicrobial resistance

Governance	Surveillance	AMU, AMC, AMS	Evaluation	Environment
<ul style="list-style-type: none"> • MNAP 2022-2025 • MSSC established • Veterinary Drug Law 2024 • Drafting regulations on veterinary drug prescriptions in the animal health sector • For Improving regulation of human drugs or medicine, National Medicines Regulatory Authority has been established • Human Drug Law • MNAP M&E framework by MPTF-FAO • Legal review of the Food and Agriculture (F&A) sector using the ACT tool • AMR Codex standard translated into Mongolian and approved as a national standard 	<ul style="list-style-type: none"> • Local lab training for veterinary labs on AST by MPTF-FAO • AMR training by JICA • AMR lab training by WOAHA in Tokyo • Epidemiology training for MOH on AMS and AMR by WHO • Lab training for MOH by WHO • Drafting of AMR surveillance national guidelines by WHO • Support to establish the national AMR surveillance system by WHO • Setting up the national AMR surveillance framework draft • Upgrading microbiology 	<ul style="list-style-type: none"> • Training for health workers on AMR, AMU, and AMC • WAAW for students, pupils, and the public • AMS trainings for all medical organizations • AMR/AMU training by WOAHA • AMU monitoring workshop by WOAHA • AMR awareness posters translated and distributed • National AMR communication strategy by WOAHA • AMR trainings for vets, herders, and food producers • Drafting of AMS implementation guidelines • AMC evaluated at the national and hospital level 	<ul style="list-style-type: none"> • FAO-PMP-AMR evaluation 2021 • WHO- lab preparedness evaluation 2024 • JEE evaluation 2023 • FAO-ACT tool assessment 2023 • GLASS evaluation, Water safety 2024 • FAO-ATLASS evaluation 2022 	<ul style="list-style-type: none"> • No actions for wild animal • Chemicals used for forest health is monitored annually by the MOFALI, MOH and MECC (e.g. List of pesticides, insecticides, disinfectants) • Chemical tranquilizers necessary for large wildlife capture need to be incorporated in the medical import approval regulations. • Annual forest inventory • Rodents and insects control needs to be coordinated with the MOFALI • Outhouse (improper toilets) related soil and

<ul style="list-style-type: none"> • An officer is responsible for AMR and AMU issues; specialization is needed • MMRA is coordinating human drug prescriptions • GAVS certifies license for veterinary drugs 	<p>laboratories of public hospitals by ADB</p> <ul style="list-style-type: none"> • Developing MNS serial standards on AST by MPTF-FAO • Participated in external PT on AST by FAO reference lab (SCVL, IVM, NRLFS, CVL) supported by ACT and MPTF-FAO • NCCD participated in Proficiency test • Pilot surveillance conducted by FAO-ACT, LCP, and MPTF 			<p>surface water contamination risks are not studied</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	----------------------------------------------------------

Action Track 6: Integrating the environment into One Health

Overview

- Integration of Environmental Policies, regulations under the One Health Approach
- Wildlife joint surveillance and research activities and environmental data sharing with One Health Partners
- One Health Training, capacity building and public communications

Key take aways

- Among the three sectors there is some level of ongoing activities on OH, while the environmental sector is new there is some level of collaboration with human and animal health sectors on research and surveillance and on OH training and capacity but needs much more engagement.

Challenges:

Further actions/remaining issues and needs:

- Legal framework on One Health inclusive of environmental sector much needed
- Disaster, climate event, One Health management, response guidelines on cross sectoral collaboration
- Children's and general human health impact due to air pollution and specific measures of control
- One Health approach raises wildlife health, however, chemical toxication, environmental toxication, plant, water, heats safety needs to be included
- Assessment of existing legal documents to include One Health
- Committee on One Health and Joint Plan integration
- Soil health and safety
- One Health capacity expertise at each sector needed
- Review of A-28 and evaluate environmental sector's engagement
- Update and integrate One Health in environmental laws
- Wild bird (wildlife) migration and population change due to climate change
- Respiratory disease is increasing, however environmental, air pollution impact on public needs a detailed research
- Food toxication is increasing, environmental impact on food toxication needs a research
- Disaster support and access is there during environmental events but needs improvement

- Dead animal carcasses due to disaster contaminating environmental, soil and pasture.
- Floods affecting human health
- Chemicals and fertilizers impacts on human health
- Marmot reintroduction from natural anthrax foci areas to new areas thus increasing transmitting and expansion risk of Anthrax.
- Air pollution leading to cancer increase
- Cross sectoral data sharing much needed
- Establish policy and legal documents on One Health including environmental sector
- Pasture regeneration activity needed
- Environmental impact on animal and public studies just beginning
- Prepare vets in wildlife health
- Animal Health Law inclusive of wildlife
- Chemical tranquillizer use in wildlife is a big barrier due to restrictions
- Cross sectoral zoonotic diseases control strategies
- Environmental sector has no One Health capacity
- Existing cross sectoral collaboration between human health and animal health. No environment
- Public awareness on One Health
- Integrate policies
- Ecosystem restoration
- Develop National Action Plan on One Health
- Community engagement on One Health
- Environmental health surveillance (MECC and MOH) exists, sharing data between NCCD, NCPH, Meteorology, MECC
- Wildlife health surveillance and research in collaboration with
- Wildlife health surveillance and research in collaboration with veterinary, human health sectors exist.



Action Track 6 brainstorming

- Existing laws, regulations, joint coordination, capacity, and integrated mechanisms in place:

Integrated legislations, OH coordination structure and system	Surveillance, research and data sharing	OH Training, capacity and community engagement	Gaps
Cross sectoral fundamental collaboration is established but environmental sector engagement is weak	Research on zoonotic disease of wildlife and livestock (i.e. parasitic, zoonotic and TAD diseases)	Wildlife health professionals in need	No Coordinated cross-sectoral Zoonotic Disease Control Strategy
OH Committee to be established	Joint field surveillance of wildlife (i.e. AI, PPR)	Protected Areas actively engaging with buffer zone herder communities to increase awareness, improve knowledge and to support local communities livelihoods through buffer zone supported certification of health herds, organic and pure natural products.	Importation of wildlife immobilization medicine has a big National Barrier due to legal medicine registration restrictions
